

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН
ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ИРГЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ АВАХ
НӨХЦӨЛ БҮРДСЭН ХЭДИЙ Ч ИРГЭДИЙН ДААТГАЛД
ХАМРАГДАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

АУДИТЫН КОД: ХЭА-2023/19-22-ШТА-ГА

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР
НӨЛӨӨ”-нд хийсэн ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**

Хэрлэн сум 2021 он



**Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ч.Эрдэнэбаатар**

Утас: 70562112 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Ц.Билэгсайхан

Утас: 88032817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Х.Еркегүл

Утас: 99040507 Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Аудитор Н.Туяа

Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог орон нутгийн эм, эмнэлгийн байгууллагууд мөрдөж ажиллаж байна.	7
А.1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог орон нутгийн эм, эмнэлгийн байгууллагууд мөрдөж ажиллаж байна.....	7
БҮЛЭГ Б: Эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтийн хувьд бие даасан байдалд шилжсэнээр ахиц дэвшил гарч байгаа ч боловсон хүчний дутагдал, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, тасалдалт зэрэг шийдвэрлэх асуудлууд байна.	8
Б.1. ЭМД-ыг өөрөө төлөгч иргэдийн даатгалд хамрагдалт хангалтгүй, санхүүжилтийн нэхэмжлэлийг журмын дагуу хянаж олгож байгаа ч урьдчилгааг гэрээнд заасан хугацаанд олгохгүй байна.	8
Б.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх тогтолцооны хүрээнд салбарын байгууллагууд цахим системд бүрэн шилжсэн байна.....	23
Б.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлэн ажилласан байна	25
Холбогдох байгууллагын санал:	30
ДҮГНЭЛТ:	31
ЗӨВЛӨМЖ:	32

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ААН	Аж ахуйн нэгж
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
УИХ	Улсын их хурал
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЗГ	Засгийн газар
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	ЭМД-ын шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэдийн хамрагдалт	9
2	ЭМД-ын хамрагдалтын 2021, 2022 оны тайлан	10
3	ЭМД-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4	Хэнтий аймгийн ЭМД-ын сангийн орлого, зарлага	12
5	Эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тооцоо	12
6	Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тооцоо.	13
7	ЭМД-ын сангийн бүртгэл, тайлангийн маягт.	14
8	Эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээ, биелэлтийг дүгнэсэн байдал.	17
9	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлөөр санхүүжилт	18
10	Хэнтий аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын нийт санхүүжилтийн өсөлт	20
11	Эрүүл мэндийн байгууллагуудын худалдаж авсан үндсэн хөрөнгийн харьцуулалт	20
12	Эмийн үнийн хөнгөлөлтийн багцын хүртээмж	21
13	ЭМД-ын шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамрагдалтын судалгаа	23
14	Нэхэмжлэлийн 2021 оны хяналтын хасагдал	26
15	Нэхэмжлэлийн 2022 оны хяналтын хасагдал	26

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Эрүүл мэндийн байгууллагуудын дутагдалтай ажиллах хүчний тоо /Их эмч/	22
2	Эрүүл мэндийн байгууллагуудын дутагдалтай ажиллах хүчний тоо /Сувилагч тусгай мэргэжилтэн/	22
3	Нэхэмжлэлийн хасагдлын шалтгаан	27

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”- г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх; ➤ Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ, аймгийн ЭМГ, аймгийн ЭМД-ын хэлтэс болон аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүд болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, холбогдох бусад байгууллагуудын 2021-2022 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж боловсруулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, аудитор Ц.Билэгсайхан, Н.Туяа, Х.Еркегүл нар хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2023 оны 03 дугаар сарын 06-аас 09-ний хооронд хийж гүйцэтгэн, талбарын үе шатны ажлыг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлж, тайлагналын үе шатыг 05 дугаар сарын 19-ний дотор дуусган, аудитын тайлан, судалгааг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2023 оны 05 дугаар сарын 19-нд Үндэсний аудитын газар болон аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

**Хүндрэл
бэрхшээл**

.....

БҮЛЭГ 1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог орон нутгийн эм, эмнэлгийн байгууллагууд мөрдөж ажиллаж байна.

А.1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог орон нутгийн эм, эмнэлгийн байгууллагууд мөрдөж ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй уялдуулан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг сайжруулахтай холбоотой цахимжуулалтыг дэмжих, эрүүл мэндийн даатгалын хамрагдалтын нэмэгдүүлэх” зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллагад цахим үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, мэдээллийн сан үүсгэх;
- Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг даатгуулагчдад сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

Эдгээр бодлогын баримт бичгийн хүрээнд аймгийн Засаг даргын сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд тухайн жилд шинээр эрүүл мэндийн даатгалд хамруулах иргэдийн тоог зааж, хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.

Мөн төрөөс ЭМД-ыг нь хариуцдаг иргэдийн тоон судалгааг гаргахад ХХҮГ болон ЭМД-ын хэлтсээс авсан тоон мэдээлэл зөрүүтэй, нэрсээр харах боломжгүй байгаа зэрэг нь хамрагдалтыг эрчимжүүлэхэд төвөгтэй байдал үүсгэж байна.

Энэ нь аймгийн ХХҮГ-т байгаа суурь тоон мэдээлэл 2017 онд хийсэн судалгаан дээр үндэслэсэн бөгөөд жил бүр цөөн мэдээллийг засах байдлаар явагддаг, оюутан суралцагчдын тоог статистик тоогоор авч байгаа боловч Хэнтий аймгаас өөр газар сурч байгаа оюутнууд тухайн газартаа ЭМД төлдөг нь орон нутагт ЭМД-ын төлөвлөгөө тасрах шалтгаан болж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.1-д зааснаар “ЭМД-ын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна” гэж тусгасан ба орон нутагт зөвлөл байх талаар тусгагдаагүй байна.

Харин ЭМДҮЗ-өөс Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.9.1-д заасан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах” чиг үүргийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот тогтоолоор “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”, 2022 оны 3 дугаар сарын 23-ны 05 дугаар тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тус тус баталжээ.

Дээрх хуулийн 14.9.10-д заасан *“Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох”* чиг үүргийн хүрээнд 2022 оны 07 дугаар сарын 04-ний 11 дүгээр тогтоолоор *“Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай”*, мөн хуулийн 14.9.11-д заасан *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах”* чиг үүргийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 28-ны 02 дугаар тогтоолоор *“Журам шинэчлэн батлах тухай”* заавар журмуудыг тус тус баталсныг аймгийн ЭМД-ын хэлтэс эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Монгол улсын “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах төсөл” 2019-2022 онд салбарын яам болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хэрэгжиж, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эхлүүлсэн байна.

Энэхүү шинэчлэлээр эрүүл мэндийн бүх нийтийн хамралт буюу нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулж, тусламж, үйлчилгээ авахаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс ард иргэдээ хамгаалах, улсын эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэгджээ.

Хэнтий аймгийн ЭМД-ын хэлтсээс гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаатай холбоотой ажилтнуудаа чадавхжуулах сургалтыг 2022 онд зохион байгуулагдсан цахим болон танхимын сургалтуудад хамруулжээ.

ЭМД-ын хэлтэс нь health.gov.mn цахим системд харилцагч эрүүл мэндийн байгууллагууд, эмийн санг холбож зардлын гүйцэтгэлийг цахимаар хүлээн авч хянан, шаардлага хангасан санхүүжилтийг олгох, санхүүжилт олгогдоогүй гүйцэтгэлийн шалтгааныг холбогдох байгууллагад хүргүүлэх, алдаа зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байх ажлыг зохион байгуулжээ.

БҮЛЭГ Б: Эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтийн хувьд бие даасан байдалд шилжсэнээр ахиц дэвшил гарч байгаа ч боловсон хүчний дутагдал, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, тасалдалт зэрэг шийдвэрлэх асуудлууд байна.

Б.1. ЭМД-ыг өөрөө төлөгч иргэдийн даатгалд хамрагдалт хангалтгүй, санхүүжилтийн нэхэмжлэлийг журмын дагуу хянаж олгож байгаа ч урьдчилгааг гэрээнд заасан хугацаанд олгохгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд

үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.”, 19.4-т “Нийгмийн даатгалын байгууллага төвлөрүүлсэн хөрөнгийг долоо хоног бүр эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлнэ” гэсэн байна.

Уг хуулийн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын болон Нийгмийн даатгалын байгууллагын хооронд хамтран ажиллах гэрээ байгуулан, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг цуглуулах, төвлөрүүлэх ажлыг гүйцэтгэж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1¹-д заасныг үндэслэн Засгийн газрын тогтоолоор эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тогтоож байна. Эрүүл мэндийн даатгалын болон Нийгмийн даатгалын байгууллагын хооронд байгуулсан гэрээний 2.1.6-д “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 , 4.3 , 25 дугаар зүйлийн 25.2 -д заасны дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 2016 оноос хойш тухайн үед мөрдөж байсан шимтгэлийн хувь, хэмжээний дагуу заавал нөхөн төлүүлнэ”² гэж заасан байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/10 дугаар тушаалаар “2021 оны эрүүл мэндийн даатгалд хамралтын төлөвлөгөө”-г, 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/13 дугаар тушаалаар “2022 оны эрүүл мэндийн даатгалд хамралтын төлөвлөгөө”-г батлахдаа Хэнтий аймгийн ЭМД-ын хэлтсийн тайлант оны “Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын төлөвлөгөө”-г тус тус баталсан байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийг даатгалд хамруулах үүднээс Хэнтий аймагт 2021 онд 14000 даатгуулагчаас 7394 даатгуулагчийг хамруулж 53 хувиар, 2022 онд 13050 даатгуулагчаас 8986 даатгуулагчийг хамруулж төлөвлөгөө 69.0 хувиар тус тус биелсэн байна.

Хүснэгт 1: ЭМД-ыг өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамрагдалт

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2021	14000	7394	6606	0.53
2022	13050	8986	4064	0.69
Дүн	27050	16380	10670	0.61

*Эх сурвалж Хэнтий аймгийн ЭМД-ын хэлтсийн мэдээ”

ЭМДЕГ-ын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын 2021, 2022 оны мэдээ тайланг аймгийн нийт хүн амын тухайн оны статистик мэдээтэй харьцуулахад 2021 онд 8120, 2022 онд 7851 иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байна. Хүснэгтээр үзүүлбэл:

¹ 8.1.Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл /цаашид “шимтгэл” гэх/-ийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар дараах байдлаар тогтооно:

8.1.1.энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар жил бүр;

8.1.2.энэ хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.9, 6.1.12-д заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар жил бүр;

² /2016 он 46080 төгрөг, 2017 он 57600 төгрөг, 2018 он 28800 төгрөг, 2019 он 38400 төгрөг, 2020 он 50400 төгрөг, 2021 он 50400 төгрөг, 2022 он 50400 төгрөг/

Хүснэгт 2: ЭМД-д хамрагдалтын 2021, 2022 оны тайлан

№	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Төлөв лөгөө	Хамраг далт	Биелэлт хувь	Төлөв лөгөө	Хамраг далт	Биелэлт хувь
1	Төсөвт болон ААН байгууллагын ажилтан	-	7588	100	-	10400	100
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	5500	1814	33.0	4950	1832	37.0
3	Малчин	7500	2466	32.9	6700	2423	36.2
4	Оюутан, суралцагч	1000	353	35.3	1400	357	25.5
5	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн		2	-	-	1	-
6	0-18 насны хүүхэд		27983	100	-	30176	100
7	Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн		15620	100	-	15163	100
8	Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн		13034	100	-	8110	100
9	Хүүхдээ асарч буй эх/эцэг		1581	100	-	2327	100
10	Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч		52	100	-	34	100
11	Ял эдэлж байгаа ялтан		354		-	285	
12	Бусад (хуулийн 6.1.12 дахь заалтын даатгуулагч)		-	-	-	-	-
НИЙТ <i>/ЭМДЕГ-ын мэдээ, тайлан/</i>		14000	70847	-	13050	71108	-
Нийт хүн амын тоо <i>/аймгийн Статистикийн хэлтсийн мэдээ/</i>			78967			78959	
Зөрүү /хамрагдаагүй хүн ам/			8120	-		7851	-

Иргэд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдахгүй байгаа нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 “Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна.”, 4.3. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна” гэж заасан хуулийг хэрэгжүүлэх талаарх иргэдийн мэдлэг хангалтгүй байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн даатгалд иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах НДХ болон ЭМД-ын хэлтсийн хоорондын ажлын уялдаа хангалтгүй байгаа, хуулийн зохицуулалт оновчгүй байгаа нь ЭМД-д хамруулах төлөвлөгөө хангалтгүй биелэхэд нөлөөлж байна.

Иймд иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах ажлыг холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар ЭМД-ын байгууллагад хариуцуулан сайжруулах нь зүйтэй байна.

ЭМДЕГ-ын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын мэдээ тайлангийн дүн нь хэлтсийн ажилтны гаргаж ирүүлсэн болон нийгмийн даатгалын байгууллагын мэдээ тайлангаас зөрүүтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар “2021 оны аймаг, нийслэлийн эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө”-г, 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/14 дугаар тушаалаар “2022 оны аймаг, нийслэлийн эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө”-г тус тус баталсан байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 2021 онд Хэнтий аймгийн ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн 4,865.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 5,172.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 106.3 хувиар, ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэний шимтгэлийн 429.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 530.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 123.6 хувиар биелүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 2022 онд Хэнтий аймгийн ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн 9,800.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 6,548.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 66.9 хувиар, ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэний шимтгэлийн 875.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 617.2 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 70.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 3: ЭМД-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/ сая.төг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	2021 он			2022 он			Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	4,865.4	5,172.4	106.3	9,800.8	6,548.6	66.9	4,935.4	1,376.2
Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, суралцагсдын шимтгэл	429.3	530.6	123.6	875.5	617.2	70.5	446.2	86.7
НИЙТ	5,294.7	5,703.0	107.7	10,676.3	7,165.8	67.1	5,381.6	1,462.9

Тус шимтгэлийн орлогын гүйцэтгэлийг авч үзэхэд 2021 онд орлогын төлөвлөгөөг 107.7 хувиар биелүүлсэн боловч 2022 онд орлогын төлөвлөгөө 67.1 хувиар биелжээ.

Хэнтий аймгийн ЭМД-ын шимтгэлийн 2022 оны орлогыг төлөвлөхдөө 2021 оны гүйцэтгэлийг 87.2 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.

ЭМД-ын сангийн орлого, зарлагын төсвийг төлөвлөх, батлуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах ажлыг ЭМДЕГ-ын төсвийн асуудал хариуцсан нэгж холбогдох журмын дагуу хариуцан хэрэгжүүлж, аймгийн ЭМД-ын хэлтэс зөвхөн эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэлийг хэрэгжүүлж ажилладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн төсөлд Нийгмийн даатгалаас төвлөрүүлэх орлогыг Сангийн яам цалингийн өсөлт, аж ахуйн нэгжүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2019 оноос хойших нөхөн төлөлт болон сангийн зардалтай уялдуулан 2021 оны батлагдсан төсвөөс нэмэгдүүлэн УИХ-аар

батлуулсныг үндэслэн аймгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Хэнтий аймгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2021, 2022 оны орлого болон зарлагын гүйцэтгэлийг харьцуулахад зарлага 2021 онд 15,588.0 сая төгрөгөөр, 2022 онд 20,502.9 сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй буюу алдагдалтай бөгөөд зөрүүг эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн үлдэгдлээс олгосон байна.

Хүснэгт 4: Хэнтий аймгийн ЭМД-ын сангийн орлого, зарлага

/сая төг/

Он	ЭМД-ын шимтгэлийн орлого				ЭМД-ын зарлага	Зөрүү
	Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл	Бусад орлого /хүү, алданги, акт/	Шимтгэлийг өөрөө төлөх иргэд	Нийт орлого	Нийт зарлага /олгохоор тооцсон санхүүжилт/	
2021	5,702.4	1.1	530.6	6,234.0	21,822.0	(15,588.0)
2022	6,548.6		617.2	7,165.8	27,668.8	(20,502.9)
Дүн	12,251.0	1.1	1,147.8	13,399.8	49,490.8	(36,090.9)

Иймд эрүүл мэндийн даатгалд хамрагдалт болон даатгалын шимтгэлийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Нэхэмжлэлийн хяналтын шалгуур”, ЭМДЕГ-ын мөн оны А/98 дүгээр тушаалаар батлагдсан “Нэхэмжлэлийн хяналт хийх журам”-ын хүрээнд 2021 онд чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хяналтыг хийсэн байна.

Нийт 11 эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр 23,514.1 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 21,821.9 сая төгрөгийн санхүүжилт буюу 92.8 хувийг олгохоор хянасан байна.

Хүснэгт 5: 2021 оны байдлаар эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний санхүүжилтийн тооцоо

/ мян.төг /

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Эхний үлдэгдэл		санхүүжилт		Эцсийн үлдэгдэл	
		авлага	өглөг	Олгохоор тооцсон	Олгосон	авлага	өглөг
1	Улсын эмнэлэг тусламж үйлчилгээ	-	-	7,058,700.4	6,944,570.7	56,899.5	171,029.2
2	ӨЭМТ эрт илрүүлэг	-	-	2,705.5	2,705.5	-	-
3	Улсын эмнэлэг урьдчилан сэргийлэх			28,983.0	10,542.0		18,441.0
4	Сувиллын дүн			441,292.8	422,542.8	-	18,750.0
5	Эмийн сангийн нийт дүн			1,057,045.2	1,009,637.2	-	47,408.0
6	Өрх, СЭМТ-ийн нийт дүн	-	-	441,318.4	441,318.4	-	-

7	Ковид-19 вакцин			594,775.0	538,362.0	-	56,413.0
8	Ковид-19 хэвтэн			10,400,520.0	5,923,201.3	-	4,477,318.7
9	Ковид-19 гэрийн тусгаарлалт			986,500.0	416,224.8	-	570,275.2
10	Тандалт -5000			73,650.0	34,937.0	-	38,713.0
11	Сорьц-50000			736,500.0	351,085.0	-	385,415.0
	Нийт дүн	-	-	21,821,990.1	16,095,126.6	56,899.5	5,783,763.0

Эрүүл мэндийн даатгалын сангаас Хэнтий аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 2021 онд 16,095.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 56.9 сая төгрөгийн авлага, 5,783.8 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Үүнээс өглөгийн 88.2 хувь буюу 5,104.0 сая төгрөг нь Ковид-19 өвчинтэй холбоотой тусламж үйлчилгээний өр бөгөөд 2022 онд төлж барагдуулсан байна.

2021 онд 6533 иргэний 1,692.1 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ санхүүжилт олгогдохгүй хасагдсан байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”, мөн ЭМДЕГ-ын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Нэхэмжлэлийг хянах журам”-ын дагуу төлбөрийн нэхэмжлэлийн хяналтыг хийж санхүүжилтийн гүйцэтгэлийг ЭМДЕГ-т тайлагнаж байна.

Аймгийн ЭМД-ын хэлтсээс нийт 14 эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр 29,785.6 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 27,668.9 сая төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор хянажээ.

Хүснэгт 6: 2022 оны байдлаар эрүүл мэндийн байгууллагуудтай тусламж үйлчилгээний санхүүжилтийн тооцоо

/ мян.төг /

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Эхний үлдэгдэл		санхүүжилт		Эцсийн үлдэгдэл	
		авлага	өглөг	Олгохоор тооцсон	Олгосон	авлага	өглөг
1	Улсын эмнэлэг дүн	56,899.5	171,029.2	12,100,055	12,214,184.6		
2	Урьдчилан сэргийлэх үзлэг дүн		18,441.0	3,436	21,877.0		
3	Эрт илрүүлэг /ЭМЯ/		-	308,555	308,555.0		
4	Сувиллын дүн		18,750.0	830,973	849,723.4		
5	Эмийн сангийн дүн		45,675.5	1,211,917	1,257,592.7		
6	С вирусн эм/дүн/		840.0	0	840.0		
7	В вирусн эм /дүн/		892.5	25,525	26,417.9		
8	Өрхийн ЭМТ-ийн дүн		-	135,890	135,889.9		
9	Сум,тэмт-ийн дүн		-	366,775	366,774.7		
10	ӨЭМТ-н анхан шатны санх /Нэг иргэн/		-	1,429,466.98	1,429,467.0		
11	СЭМТ-н анхан шатны санх / Нэг иргэн/		-	5,713,883.81	5,713,883.8		
12	Шинэ 4 тусламж үйлчилгээСТЭМТ		-	3,726,719	3,726,718.7		
13	Ковид-19 вакцин		56,413.0	59,180	115,593.0		
14	Ковид-19 хэвтэн		4,477,318.7	1,323,125.00	5,800,443.7		

15	Ковид-19 өрхийн тусгаарлалт		570,275.2	310,720	880,995.2		
16	Тандалт -5000		38,713.0	11,155	49,868.0		
17	Сорьц-50000		385,415.0	111,550	496,965.0		
	Нийт	56,899.5	5,783,763.0	27,668,926.0	33,395,789.5		

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 онд эрүүл мэндийн байгууллагуудад өмнөх оны өр болон тайлант оны тусламж үйлчилгээний санхүүжилтэд 33,395.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, тайлант онд өр, авлагын үлдэгдэлгүй тайлагнасан байна. Гэвч 2022 оны 11, 12 сарын нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувь 190.5 сая төгрөгийг 2023 оны 2 дугаар сард өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлснийг 2022 оны тайлан, мэдээнд тусгаагүй байна.

ЭМДҮЗ болон ЭМДЕГ-аас эрүүл мэндийн даатгалаас нэг иргэнээр тооцон олгох санхүүжилтийг сум, тосгоны эрүүл мэндийн төвд хуваарилж, шинэчилж баталсан төсөв тодорхой биш байгаагаас аймгийн ЭМД-ын хэлтэс төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргах боломжгүй байна.

Эндээс үзэхэд мэдээ тайланд өглөгийг үнэн зөв тусгаагүй, ЭМД-ын хэлтэс болон ЭМДЕГ-ын мэдээ, тайланг эцэслэн тулгаж баталгаажуулдаггүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/591 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын санхүү бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг батлан 2020 оны 1 дүгээр сарын 1-ээс, 2022 оны А/355 дугаар тушаалаар дээрх маягтуудыг шинэчлэн баталж 2022 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс мөрдсөн байна.

Хүснэгт 7: Эрүүл мэндийн даатгалын сангийн бүртгэл, тайлангийн маягт

№	ЭМС-ын 2019.12.20-ны а/591 дүгээр тушаал	ЭМС-ын 2022.07.06-ны а/355 дугаар тушаал
1	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын тайлангийн хавсралт -ЭМД11	Эрүүл мэндийн даатгалын сангаас ... оны сард санхүүжүүлсэн тусламж, үйлчилгээний зардал маягт-1а
2	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн оны тусламж үйлчилгээний зардал-ЭМД№11 /аймаг, нийслэлээр/	Эрүүл мэндийн даатгалын сангаас ... оны сард санхүүжүүлсэн тусламж, үйлчилгээний зардал /Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр/ маягт-1б
3	Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн нэгтгэл ЭМД-Н0	Эрүүл мэндийн даатгалын сангаас ... оны сард санхүүжүүлсэн тусламж, үйлчилгээний зардал /аймаг, нийслэлээр/ маягт-1в
4	Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн нэгтгэл ЭМД-Н1	Эрүүл мэндийн даатгалын сангаас оны сард санхүүжүүлсэн эмийн зардал маягт-2
5	 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын дугаар улирлын байдлаар тооцоо нийлсэн актын нэгтгэл ЭМД -Н2	Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн нэгтгэл Маягт-3
6	 аймгийн гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын дугаар сарын тусламж, үйлчилгээний	Баталгаажуулах хуудас Маягт-4
7		Тооцоо нийлсэн актын нэгтгэл Маягт-5

Аймгийн ЭМД-ын хэлтэс уг маягтын дагуу тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бүртгэл, тайланг гаргаж, ЭМДЕГ-т 2021-2022 онд хүргүүлж ажилласан байна.

ЭМДЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн "Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийн нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/10 дугаар тушаалаар Хэнтий аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн бүтцийг хэлтсийн дарга 1, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 4, нийт 5 орон тоотой баталж, батлагдсан орон тоогоор чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТАЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны 99 дүгээр тогтоолоор хянаж баталгаажуулсан албан тушаалын тодорхойлолтыг ЭМДЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ний А/45 дугаар тушаалаар баталсны дагуу ажил үүргийн нарийвчилсан хуваарийг гарган ажиллаж байна.

Аймгийн ЭМД-ын хэлтсийн 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ЭМДЕГ-т хүргүүлж, 2021 онд 86.5 хувьтай буюу сайн, 2022 онд 90 хувьтай буюу маш сайн дүгнэгдсэн байна.

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь төсөв захиран зарцуулдаггүй, ЭМДЕГ-ын салбар байгууллага бөгөөд үйл ажиллагаатай холбоотой зардлын тооцоо, холбогдох материалыг ЭМДЕГ-т тогтоосон хугацаанд хүргэж ажилласан байна.

ЭМДҮЗ-ийн 2018 оны 9 дүгээр тогтоолоор баталсан *“Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”*, ЭМДҮЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоолоор 1 дүгээр хавсралтаар батлагдсан *“Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь төр хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”*-ыг үндэслэн ЭМДЕГ-аас 2021 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулсан байна.

Улмаар ЭМДҮЗ-ийн 2022 оны 1 дүгээр сарын 28-ны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”*-ыг 2022 оноос мөрдөж, сонгон шалгаруулалтыг ЭМДЕГ-ын Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн асуудал хариуцсан нэгж зохион байгуулахаар журамласан байна.

Дээрх журмын хүрээнд ЭМДЕГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад 2022 онд Хэнтий аймгаас төрийн өмчийн 3 эмнэлэг, хувийн хэвшлийн 2 рашаан, сувилал материалаа Selection.1818.mn вэб сайтаар дамжуулан хүргүүлсэн байна.

Үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 349 оношийн хамааралтай бүлгээр, Бор-Өндөр сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлэг нь 253 оношийн хамааралтай бүлгээр, Уламжлалт анагаах ухааны эмнэлэг нь 10 оношийн хамааралтай бүлгээр, “Чингисийн гурван нуур” сувилал 1 оношийн хамааралтай бүлгээр, “Дархан оточ

аварга” сувилал 14 оношийн хамааралтай бүлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн байна.

Хэнтий аймгийн ЭМД-ын хэлтсээс 2022 онд сонгон шалгаруулалтын хэрэгжилтэд ЭМДЕГ-ын 2022 оны А/154 дүгээр тушаалаар баталсан ажлын бүрэлдэхүүн, удирдамж, чиглэлийн дагуу газар дээрх хяналт шалгалтыг Дархан, Бор-Өндөр сумын эмнэлэг, “Дархан оточ” рашаан, сувиллын газарт 11 оношийн хамааралтай бүлгийн хүрээнд хийж тайлан мэдээг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.

ЭМДЕГ-ын 2018 оны А/142 тушаалаар батлагдсан *“Даатгалын гэрээ дүгнэх журам”*, 2022 онд шинэчлэн баталсан ЭМДЕГ-ын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/56 тушаалаар батлагдсан *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай гэрээ байгуулах журам”*, мөн газрын 2022 оны А/61 дүгээр тушаалаар *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийг үнэлэх, урамшуулал олгох журам”*-ыг мөрдөж байна.

ЭМДЕГ-аас 2021 онд лавлагаа шатлалын 5 эмнэлэг, хувийн хэвшлийн 2 рашаан сувилал, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг 4 өрхийн ЭМТ, 17 сумын ЭМТ, 4 тосгоны ЭМТ, эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх хувийн хэвшлийн 59 эмийн сан зэрэг нийт 89 эрүүл мэндийн байгууллага, 2022 онд лавлагаа шатлалын 3 эмнэлэг, хувийн хэвшлийн 2 рашаан сувилал, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх 4 өрхийн ЭМТ, 21 сум, тосгоны ЭМТ-тэй *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”*, эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх хувийн хэвшлийн 40 эмийн сантай *“Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”* зэрэг 70 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулсан байна.

ЭМДЕГ-ын 2021 оны А/07 тушаалаар *“2020 оны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх даатгалын гэрээ”*-г дүгнэж, шалгуур үзүүлэлтийг хангасан 5 эмнэлэг, 19 сум, тосгоны эрүүл мэндийн төв, 4 өрхийн эмнэлэг, 2 рашаан сувилалтай 2021 онд даатгалын гэрээг үргэлжлүүлэн байгуулж, 3 шүдний эмнэлэг даатгалын гэрээ байгуулаагүй байна.

Лавлагаа шатлалын 5 эмнэлэгтэй байгуулсан 2021 оны *“Даатгалын гэрээ”*-ний биелэлтийг *“Хангалттай”* гэж дүгнэж 2022 оны ЭМДЕГ-ын А/31 тушаалаар баталгаажуулан 2022 онд 1 сард *“төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”* байгуулсан байна.

Улмаар ЭМДЕГ-тай 2022 оны 9 дүгээр сард байгуулсан лавлагаа шатлалын 3 эмнэлэг, хувийн хэвшлийн 2 рашаан, сувилалтай *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”*-г 3 жилээр шинэчлэн байгуулсан ба гэрээний биелэлтийг үнэлээгүй байна.

Энэ нь *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийг үнэлэх, урамшуулал олгох журам”*-ын 2.1-д *“ЭМДЕГ-ын сонгон шалгаруулалт, гэрээлэлт хариуцсан нэгж нь ЭМБ-тай байгуулсан даатгалын гэрээг үнэлэхдээ гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийн биелэлт, тухайн жилд*

ЭМДЕГ-т ирүүлсэн ЭМБ-ын талаарх иргэдийн өргөөл, гомдол, нэхэмжлэлийн хяналтын үр дүнд үндэслэн жилд 1 удаа үнэлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх өрх, сум, тосгоны ЭМТ-дэд 2021 оны гэрээг дүгнэж, 2022 онд 25 байгууллагад “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ” байгуулсан боловч 2022 оны гэрээг дүгнээгүй байна.

Эмийн сантай байгуулсан 2021 оны даатгалын гэрээний биелэлтийг 2018 оны А/142 дугаар тушаалаар баталсан “Даатгалын гэрээ дүгнэх журам”-ыг үндэслэн дүгнэж 2022 онд Хэнтий аймгийн 40 эмийн сангийн даатгалын гэрээг үргэлжлүүлэн байгуулах, 20 эмийн сангийн даатгалын гэрээг цуцлахаар баталсан байна.

Мөн ЭМДЕГ-ын 2023 оны А/01 дүгээр тушаалаар “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийг үнэлэх журам”-ыг үндэслэн 2022 оны даатгалын гэрээг дүгнэхэд 35 эмийн сан хангалттай үнэлэгдсэн байна.

Гэрээ байгуулсан 1 эмийн сан хангалтгүй үнэлэгдсэн, 3 эмийн сан өөрийн хүсэлтээр гэрээг цуцлуулсан, 1 эмийн сан нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгуулаагүй байна.

Хүснэгт 8: ЭМБ-тай байгуулсан гэрээ, биелэлтийг дүгнэсэн байдал

	2021 он		2022 он	
	Гэрээ байгуулсан тоо	Гэрээний биелэлтийг дүгнэсэн тоо	Гэрээ байгуулсан тоо	Гэрээний биелэлтийг дүгнэсэн тоо
Лавлагаа шатлалын ЭМБ	5	5	3	0
Өрх, сум, тосгоны ЭМТ	23	23	25	0
Рашаан,сувилал	2	2	2	0
Эмийн сан	59	40	40	35
Нийт	89	70	70	35

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу анхан шатны суурь тусламж, үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэлбэрээр, зарим төрлийн оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрийн тусламж, үйлчилгээг тохиолдолд бүрд төлбөр олгох хэлбэрээр, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлдэг хэвтүүлэн эмчлэх, яаралтай, түргэн тусламж, шүдний тусламж, үйлчилгээг лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлж буй оношийн хамааралтай бүлгийн санхүүжилтийн аргаар тус тус санхүүжүүлж байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэхийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэсэн 4 гол багцыг ЭМД-ын сангийн санхүүгийн чадамжид тулгуурлан тодорхойлж, гэрээ байгуулан санхүүжүүлж байна.

Мөн 2021 онд Ковид-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор уг өвчний үеийн тандалт, дархлаажуулалт, гэрийн тусламж, үйлчилгээ, тусгаарлалт, хэвтүүлэх эмчлэх тусламж, үйлчилгээний цогц багцыг гаргаж хэрэгжүүлсэн байна. Дээрх багц үйлчилгээний хүрээнд 2021, 2022 онд 14 төрлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ЭМД-ын сангаас санхүүжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 9: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр олгосон санхүүжилт:

№	Тусламж үйлчилгээний төрөл	Олгосон санхүүжилт				Зөрүү	
		2021 он		2022 он			
		Хүн	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Хүн	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Хүн	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/
1	Лавлагаа шатлалын	118309	7,058.7	140762	12,100.1	22453	5,041.4
2	Илрүүлгийн	773	2.7		-	(773)	(2.7)
3	Урьдчилан сэргийлэх	583	29.0	85	3.4	(498)	(25.5)
4	Эрт илрүүлгийн		-	2297	308.6	2297	308.6
5	Рашаан сувиллын	1745	441.3	2458	831.0	713	389.7
6	Эмийн сангийн	40262	1,057.0	44865	1,237.4	4603	180.4
7	Өрх, сум тосгоны ЭМТ-ийн	12195	441.3	12138	502.7	(57)	61.3
8	Нэг иргэнээр санхүүжих		-	79429	7,143.4	79429	7,143.4
9	Шинэ 4 төрлийн ТҮ		-	35570	3,726.7	35570	3,726.7
10	Ковид-19 вакцины	118955	594.8	11836	59.2	(107119)	(535.6)
11	Ковид-19 хэвтэн эмчлүүлэх	8425	10,400.5	1038	1,323.1	(7387)	(9,077.4)
12	Ковид-19 гэрийн тусгаарлалтын	6242	986.5	1942	310.7	(4300)	(675.8)
13	Тандалт -5000-ын	14730	73.7	2231	11.2	(12499)	(62.5)
14	Сорьц-50000-ын	14730	736.5	2231	111.6	(12499)	(625.0)
	Дүн	336949	21,822.0	336882	27,668.9	(67)	5,846.9

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2022 онд 3 төрлийн үйлчилгээ шинээр нэмэгдэж, 2022 оны 4 дүгээр сараас Ковид-19 цар тахлын вакцин, хэвтэн эмчлүүлэх, гэрийн тусгаарлалтын санхүүжилтийг зогсоосон байна.

ЭМДҮЗ-өөс 2021 оноос эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй тусламж, үйлчилгээний нэр төрлийг тогтоож, түүний өртөг зардлыг тооцож оношийн хамааралтай бүлэг бүрд тариф тогтоож, гүйцэтгэлээр санхүүжүүлж байна.

Түүнчлэн 2022 оноос анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилт нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийн хэлбэрээс Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн байна.

Энэ өөрчлөлтийн хүрээнд ЭМДҮЗ-ийн 2022 оны 5 дугаар тогтоол батлагдаж өрх, сум тосгоны ЭМТ-өөс үзүүлэх тусламж үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүжүүлэхээс гадна түргэн тусламжийн үйлчилгээ, яаралтай тусламж үйлчилгээ, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, шүд, амны хөндийн

тусламж, үйлчилгээ/4 төрлийн/ тусламж үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар ЭМД-ын сангаас санхүүжүүлж байна.

Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх урьдчилгаа болгож “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.1.2-д тусгасны дагуу 2021 онд өмнөх сарын гүйцэтгэлийн санхүүжилтийн 70 хүртэлх хувийг, 2022 онд 50 хүртэлх хувиар тооцон сар бүрийн 11-ний дотор олгож, үлдэгдэл санхүүжилтийг тусламж үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлд холбогдох журмын дагуу чанарын болон төлбөрийн хяналт хийсний дараа олгодог байна.

Өрх, сум, тосгоны ЭМТ-тэй байгуулсан “анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.1.2-д заасны дагуу төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээг нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80 хувийн урьдчилгаа өгч, 20 хувийг шалгуур үзүүлэлтэд үндэслэн олгохоор заасан байна.

Гэвч санхүүжилтийг гэрээнд дурдсан хувийг 2022 оны 4 дүгээр сараас эхлэн 10 дугаар сарыг дуустал мөрдөлгүй ЭМДЕГ-аас олгосон бөгөөд ЭМДҮЗ-ийн 2022 оны 14 дугаар тогтоолын дагуу 11 дүгээр сараас гэрээний дагуу хянаж, хүрэх түвшиндээ хүрсэн эсэхэд үнэлгээ хийхэд Хэнтий аймгийн өрх, сум, тосгоны 25 эрүүл мэндийн байгууллагаас 2 нь гэрээний шаардлага хангаж, 23 нь гэрээний шаардлагыг хангаагүй гэж дүгнэж 2022 оны 11, 12 дугаар сарын ЭМД-ын санхүүжилтийн үлдэгдэл 20 хувийг олгоогүй байна.

Мөн гэрээний 2.1.2, 2.1.3-д заасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн урьдчилгаа санхүүжилтийг сар бүрийн 11-ний өдрийн дотор олгохоор заасан боловч, гэрээний заалт хэрэгжүүлэлгүй дараа сард нь гүйцэтгэлийг тооцож, сар дамжуулан нэг удаа олгож гэрээний заалтыг хэрэгжихгүй байна.

Эмийн сангийн хувьд “даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний 2.1.2-д иргэн даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний урьдчилгаа болгож 2021 онд өмнөх сарын гүйцэтгэлийн санхүүжилтийн 70 хүртэлх хувийг, 2022 онд 50 хүртэлх хувиар тооцон олгохоор заасан боловч гэрээний энэ заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн гэрээний 2.4.7-д төсвийн тухай хуулийн заасан санхүүгийн тайлангийн цаглавартай холбогдуулан тухайн жилийн 6 болон 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн дараа сарын нэхэмжлэлтэй хамт ЭМД-ын байгууллагад хүргүүлж, санхүүжилтээ авахаар гэрээлсэн байна.

Урьдчилгааг гэрээнд заасан хугацаанд олгодоггүй, хагас жилийн болон жилийн эцсийн санхүүжилтийн гүйцэтгэлийг сар дамжуулан олгож байгаа нь анхан шатны эрүүл мэндийн байгууллага, эмийн сангуудын хэвийн үйл ажиллагаа явуулахад санхүүгийн хувьд хүндрэл үүсгэж байна.

Эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Хэнтий аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт нь 2020 онтой харьцуулахад 2021 онд 14.2 хувь, 2022 онд 39.5 хувь тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10: Хэнтий аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн өсөлт

	2020 он	2021 он	2022 он
Олгосон санхүүжилт /сая төгрөгөөр/	19,048.6	21,759.3	26,573.6
Өсөлтийн хувь	-	14.2%	39.5%

Дээрх хүснэгтээс харахад эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнээр эрүүл мэндийн байгууллагууд бодит гүйцэтгэлээр санхүүжилт авч, санхүүгийн хувьд бие даасан байгууллага болох боломж нь бүрдсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын худалдаж авсан эмнэлгийн зориулалттай үндсэн хөрөнгийг 2020 онтой харьцуулахад 2021 онд 32.7 хувиар буурсан, 2022 онд 57.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн тусгай шаардлага бүхий тоног төхөөрөмжийг худалдаж авснаар иргэд, даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар дээшилж байна.

Хүснэгт 11: Эрүүл мэндийн байгууллагуудын худалдаж авсан үндсэн хөрөнгийн харьцуулалт

	2020 он	2021 он	2022 он
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	522.7	351.4	824.6
Өсөлтийн хувь	-	- 32.7%	57.7%

Цалин хөлс, урамшууллын хувьд 2022 онд 5 эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнг тооцон 3,752.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн зэрэг гүйцэтгэлийн санхүүжилтийн үр нөлөө гарч эхэлсэн байна.

Хөнгөлөлттэй эмийн хүртээмж, эмийн сонголт нэр төрлийг оновчтой болгох, чирэгдлийг бууруулах зорилгоор 2020 оноос эхлэн эмийн үнийн хөнгөлөлтийн жагсаалтад оруулах эмийн нэр төрөл, хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох аргачлал боловсруулан лавлагаа шатлалын эмнэлгийн эмч нар хөнгөлөлттэй эм бичих эрхийг нээж эм авах журам, нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна.

Эмийн үнийг 2020 оноос хойш 30-70 хувийг хөнгөлж байсан бол 2022 оноос эхлээд уналт таталтай хүүхдийн эмийг ЭМД-ын сангаас 100 хувь хөнгөлөхөөр шинэчлэн баталж хэрэгжүүлж эхэлсэн байна.

Хүснэгт 12: Эмийн үнийн хөнгөлөлтийн багцын хүртээмж

	2020 он	2021 он	2022 он
Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчийн тоо	30877	40262	44865
Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчийн өсөлтийн хувь	-	30.3%	45.3%
Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт /сая төгрөг/	644.8	1,057.0	1,237.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн өсөлт		63.9%	91.9%

ЭМД-ын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох тогтолцоонд шилжсэнээр хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлж буй иргэдийн тоо 2020 онтой харьцуулахад 2021 онд 30.3 хувиар, 2022 онд 45.3 хувиар тус тус өссөн нь хөнгөлөлттэй эмийн хүртээмж нэмэгдсэнийг харуулж байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нийт 123 их эмч ажиллахаас 84 эмч ажиллаж 31.7 хувийн, лавлагаа шатлалын байгууллагад 109 их эмч ажиллахаас 96 ажиллаж 11.9 хувийн дутагдалтай байна.

Мөн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нийт 229 сувилагч, тусгай мэргэжилтэн ажиллахаас 202 хүн ажиллаж 11.8 хувийн, лавлагаа шатлалын байгууллагад 207 сувилагч, тусгай мэргэжилтэн ажиллахаас 192 хүн ажиллаж 7.2 хувийн дутагдалтай ажиллаж байна.

Гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэн боловч эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байгаа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, төрөл, гүйцэтгэлийн санхүүжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Үүнд анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллавал зохих их эмчийн орон тооны дутагдлаас үүдэн ажлын ачаалал нэмэгдэж цахим системд бодит цагийн горимоор үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний мэдээллийг бүрэн оруулж амжихгүй байдгаас үзүүлсэн үйлчилгээний нэхэмжлэлийн төлбөрийг бүрэн авч чадахгүй хасуулдаг байна.

Жишээлбэл: Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн 26 байгууллагаас 8 эрүүл мэндийн байгууллагад их эмч орон тоогоор ажиллаж байгаа бол бусад 18 эрүүл мэндийн байгууллагад 39 их эмч дутагдалтайгаас Баянхутаг, Норовлин, Галшар, Дэлгэрхаан сум, Хэрлэнбаян-Улаан, Тахилгат тосгонд тус тус 1 их эмч ажиллаж байна.

График 1: Эрүүл мэндийн байгууллагуудын дутагдалтай ажиллах хүчний тоо /Их эмч/





График 2: Эрүүл мэндийн байгууллагуудын дутагдалтай ажиллах хүчний тоо /Сувилагч тусгай мэргэжилтэн/



Анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг аймгийн ЭМГ-т нэгдсэн журмаар зохион байгуулж сумдад хуваарилж байгаагаас шаардлагатай эм, тарианы тасалдал үүсэх, хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдах, тусламж, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 4 зүйлийн 4.1 “Дараах этгээд захиалагч байна:”, 4.1.1 “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тухайлбал Галшар, Дархан сумын ЭМТ-тэй байгуулсан эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээнд эм, тарианы нэр, төрөл, тоо хэмжээ, хугацааг тодорхой тусгаагүй, мэдээллийг хүргэдэггүй нь байгууллага хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг зохион байгуулснаар эм, тарианы чанар хүртээмж сайжирч, гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоотой байгууллага бие даан үйл ажиллагаа явуулах боломж бүрдэх юм.

Б.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх тогтолцооны хүрээнд салбарын байгууллагууд цахим системд бүрэн шилжсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2. "Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна", 4.5. "Эрүүл мэндийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын байгууллага эрхэлнэ" гэж тусгасан байна.

Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн дараах тусламж, үйлчилгээний зардлыг тухайн иргэн эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамааран ЭМД-ын сангаас бүрэн санхүүжүүлэх"-ээр баталсныг аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөж байна.

Аймгийн НДХ-ийн тайлангаар ЭМД-ын шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 2021 онд 33.7 хувь, 2022 онд 32.9 хувь байна.

Хүснэгт 13: ЭМД-ын шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамрагдалтын судалгаа

№	Үзүүлэлт	2021			2022		
		Төл	Хамраг далт	Хамралт хувь	Төл	Хамраг далт	Хамралт хувь
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	5,500	1,814	33.0	4,950	1,832	37.0
2	Малчин	7,500	2,466	32.9	6,700	2,423	36.2
3	Оюутан, суралцагч	1,000	353	35.3	1,400	357	25.5

Дээрх иргэдийн эрүүл мэндийн даатгал төлөлтийг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс 2022 онд аймгийн Политехник коллежийн нийт 473 суралцагчийн бүртгэлийн дагуу цахимд шалгаж эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөөгүй 33 хүний 3.3 сая төгрөг, ШШГГ-ын 419-р нээлттэй хорих ангид

ял эдэлж байгаа 120 хоригдлуудын 2019 оноос хойших шимтгэлийг бүрэн төлүүлэх ажлыг зохион байгуулжээ.

Оюутан суралцагчийн ЭМД-д хамрагдалтын хувь хангалтгүй байгаагийн шалтгаан нь Хэнтий Политехник коллежид суралцагчдын зарим хэсэг нь 18 насанд хүрээгүй, халамжид бүртгэлтэй иргэд, ШШГГ-ын хүмүүжигчид суралцдагаас төрөөс ЭМД-ыг хариуцдаг, өөр орон нутагт суралцдаг оюутнууд тухайн газартаа ЭМД-аа төлдөг нь оюутнуудын хамрагдалтыг бууруулж байна.

Харин 2022 онд сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээний хүрээнд сум, тосгодод нийтдээ 2895 малчныг шинээр эрүүл мэндийн даатгалд хамруулжээ.

Аймгийн хэмжээнд 15 удаагийн мэдээлэл сурталчилгааны сургалтыг зохион байгуулж эрүүл мэндийн даатгал, насны бүлгийн үзлэгт 660 иргэн хамрагдсан бол 18 төрлийн мэдээлэл бүхий материалыг 21650 иргэнд тарааж, цахимаар 41100 хүний хандалт авч, 18700 хүн бусдад хуваалцсан байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар өөрийн цахим систем болох health.gov.mn-ыг хөгжүүлэн ашиглаж байгаа ба Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, харилцаа, холбооны яамнаас өгсөн чиглэлийн дагуу ЭМДЕГ өөрийн цахим системийг түшиглэн 13А маягтыг цахимаар илгээх, хүлээн авах, иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-аас харах нөхцөл бололцоог бүрдүүлсэн.

H-info программыг бүх эрүүл мэндийн байгууллага, e-health программыг аймгийн болон Бор-Өндөр сумын эмнэлэг, e-hospital программыг анхан шатны 25 эрүүл мэндийн байгууллага, health.gov.mn-ыг бүх эрүүл мэндийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Үүнээс Хэнтий аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд өөрийн программ хангамжгүй, ЭМД-ын байгууллагын цахим системд мэдээлэл оруулах байдлаар ажиллаж байгаад тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх шинэчлэлийн хүрээнд 2022 оны сүүлийн хагаст "Аксис системс" ХХК-ийн хөгжүүлж буй E-Hospital программд шилжин ашиглаж байгаа.

Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой цахимжуулалтыг дэмжиж өнгөрсөн 2022 онд орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн нийт 24.4 сая төгрөгийн 14 ширхэг компьютерыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, 4 өрхийн ЭМТ-д олгосон ба цахим программ хангалт /e-health/ ашиглалт 75 хувьтай байна.

Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт киоск машиныг ашиглалтад оруулж иргэд үзлэгийн цаг авах болон лабораторийн шинжилгээг хүлээгдэлгүй авах боломж бүрдсэн.

Сар бүр шинээр гарсан тушаал шийдвэртэй холбоотойгоор ЭМБ-ууд цахим хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна.

Улмаар 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт 63 сая төгрөгийн өртөгтэй сервер, компьютерын тоног төхөөрөмж шинээр хангахаар төлөвлөсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.11 "эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах"-д заасан чиг үүргийн хүрээнд emd.gov.mn сайт, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар”, аймгийн ЭМД-ын хэлтсийн “Хэнтий аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс” нийгмийн сүлжээний цахим хуудсаар дамжуулан эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.

2022 онд Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн цахим системд иргэн даатгуулагчийн мэдээллийг үндсэн баримтыг үндэслэн засварлах чиглэлийн 7 өргөдлийг бичгээр хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.

Мөн аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн лавлах утас 70562001 дугаараар иргэдэд эрүүл мэндийн даатгалтай холбоотой лавлагаа, зөвлөмжийг тогтмол өгч ажиллаж байгаа бөгөөд 2022 онд төрөөс эрүүл мэндийн төлбөрийг хариуцдаг нийт 191 иргэний даатгал төлөлтийн тасарсан хугацааны засварыг хийж үйлчилсэн байна.

Б.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлэн ажилласан байна

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлэх, тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дээрх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон ЗГ-ын 2020 оны 206 тушаалаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хүрээнд ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/132 дугаар тушаалын дагуу ЭМДЕГ-аас аймгийн ЭМД-ын хэлтсийн үйл ажиллагаа, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчлэл, ЭМДҮЗ-өөс гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж 6 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аймгийн ЭМД-ын хэлтэс нь ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Нэхэмжлэлийн хяналтын шалгуур”, ЭМДЕГ-ын 2021 оны А/98 дүгээр тушаалаар баталсан "Нэхэмжлэлийн хяналт хийх журам"-ын хүрээнд чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хяналтыг хийсэн байна.

2021 онд нийт 11 эрүүл мэндийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 343482 иргэний 23,513.6 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 336949 иргэний 21,821.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 6533 иргэний 1,692.1 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хассан байна.

Хүснэгт 14: Нэхэмжлэлийн 2021 оны хяналтын хасагдал

№	Тусламж үйлчилгээний төрөл	Нэхэмжилсэн		Олгохоор тооцсон		Хасагдсан	
		Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	хүн	Мөнгөн дүн
1	Лавлагаа шатлал	120860	7,836.5	118309	7,058.7	2551	777.8
2	Эрт илрүүлэг	773	2.7	773	2.7	-	-
3	Урьдчилан сэргийлэх	609	29.7	583	28.9	26	0.7
4	Рашаан сувилал	2090	527.8	1745	441.3	345	86.5
5	Эмийн сан	40578	1,065.1	40262	1,057.1	316	8.0
6	Өрх, сум тосгоны ЭМТ	12715	459.5	12195	441.3	520	18.2
7	Ковид-19 вакцин	118955	594.7	118955	594.8	-	-
8	Ковид-19 хэвтэн	8689	10,975.1	8425	10,400.5	264	574.6
9	Ковид-19 гэрийн тусгаарлалт	7411	1,175.5	6242	986.5	1169	189.1
10	Тандалт -5000	15401	77.0	14730	73.6	671	3.3
11	Сорьц-50000	15401	770.0	14730	736.5	671	33.6
Нийт		343482	23,513.6	336949	21,821.9	6533	1,691.8

2022 онд ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор “Чанар, төлбөрийн хяналтын журам”, ЭМДЕГ-ын 2022 оны А/139 дүгээр тушаалаар "Нэхэмжлэлийг хянах журам"-ыг шинэчлэн баталсны дагуу нэхэмжлэлийн хяналтыг хийж, санхүүжилтийг олгосон бөгөөд гүйцэтгэлийг ЭМДЕГ-т тайлагнаж, эрүүл мэндийн байгууллагуудад сар бүр эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Тухайн онд 13 эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр 347027 иргэний 29,785.6 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 336882 иргэний 27,668.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 10145 иргэний 2,166.7 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хассан байна.

Хүснэгт 15: Нэхэмжлэлийн 2022 оны хяналтын хасагдал

№	Тусламж үйлчилгээний төрөл	Нэхэмжилсэн		Олговол зохих		Хасагдсан	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Лавлагаа шатлал	147510	3,625.6	140762	12,100.1	6748	1,526.6
2	Урьдчилан сэргийлэх	85	3.4	85	3.4	-	-
3	Эрт илрүүлэг	2738	356.3	2297	308.6	441	47.8
4	Рашаан сувилал	2661	902.4	2458	831.0	203	71.4
5	Эмийн сан	45180	1,248.1	44865	1,237.4	315	10.6
6	Өрх, сум тосгоны ЭМТ	13291	564.0	12138	502.7	1153	61.3
7	Нэг иргэн	79429	7,143.4	79429	7,143.4	-	-
8	Шинэ 4 ТҮ	35570	3,726.7	35570	3,726.7	-	-
9	Ковид-19 вакцин	11836	59.2	11836	59.2	-	-
10	Ковид-19 хэвтэн	1231	1,638.3	1038	1,323.1	193	315.2
11	Ковид-19 гэрийн тусгаарлалт	2382	377.7	1942	310.7	440	66.9

12	Тандалт -5000	2557	12.8	2231	11.2	326	1.6
13	Сорьц-50000	2557	127.8	2231	111.6	326	16.3
Нийт		347027	29,785.7	336882	27,668.9	10145	2,116.7

Нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тоог харьцуулан үзвэл 2021 онд нийт нэхэмжлэлийн 1.9 хувь нь хасагдаж байсан бол 2022 онд 2.9 хувь болон өссөн байна. Харин нэхэмжлэлийн хасагдлыг мөнгөн дүнгээр харьцуулан үзвэл 2021 онд 7.2 хувь байсан бол 2022 онд 7.1 хувь болон буурсан байна.

2022 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг 5828 иргэний 1,188.7 сая, Бор-Өндөр сумын хөдөөгийн Нэгдсэн эмнэлэг 1384 иргэний 273.3 сая, Уламжлалт анагаах ухааны төв 131 иргэний 63.4 сая төгрөгийн нэхэмжлэлийг хасуулсан байна.

Үүний улмаас аймгийн Нэгдсэн эмнэлэг 2022 оны санхүүгийн тайлангаар 916.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний зардлын өртэй гарсан байна.

2021 онд олгосон санхүүжилтийн ихэнх хувийг лавлагаа шатлалд 32.3 хувь, коронавирус халдварын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 47.7 хувийг олгосон бол 2022 онд лавлагаа шатлалд 43.7 хувь, нэг иргэнээр тооцсон санхүүжилтэд 25.8 хувь, эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 13.5 хувийг тус тус олгожээ.

График 3: Нэхэмжлэлийн хасагдлын шалтгаан



Эмчийн хасагдал: эмнэл зүйн удирдамж мөрдөөгүй, анхан шатны маягт ирүүлээгүй, өвчний түүхийн паспортын хэсгийг бүрэн, дэлгэрэнгүй хөтлөөгүй, онош тодруулах, баталгаажуулах, холбогдох оношилгоо, шинжилгээг хийгээгүй, хэвтэх үеийн зовуурь, амьдралын түүх, өвчний түүхийг дутуу бичсэн, клиникийн оношийн үндэслэл бичигдээгүй, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаалын хавсралтад заагдсан үзлэгийг бүрэн хийгээгүй, эмчилгээний явцад

эмчлэгч эмч үзлэг хийсэн тухай тэмдэглэлийг өдөр бүр хөтлөөгүй, үйлчлүүлэгчид дэлгэрэнгүй зөвлөгөө өгч өрх, сум, тосгоны болон мэргэжлийн эмчийн хяналтад гаргасан тухай тэмдэглэл бичээгүй, эмнэлэгт хэвтсэнээс хойш хийгдсэн оношилгоо, шинжилгээг тухайн хэвтэж байгаа эмнэлэгтээ хийлгээгүй, төрөлтийн түүхийн төрсний дараах үеийн байдлын үнэлгээг бүрэн дэлгэрэнгүй хөтлөөгүй, эхийн сэтгэл зүйн байдлыг үнэлээгүй, эхэд өгсөн зөвлөмж байхгүй, төрөлтийн партограмм хөтлөөгүй.

Цахимын хяналтын хасагдал: Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт байхгүй, давхардуулж нэхэмжилсэн, оношийн хамааралт бүлгийг буруу нэхэмжилсэн, мэс заслын үйлдлийн кодыг буруу нэхэмжилсэн.

Нийт хасагдсан нэхэмжлэхийн 74.6 хувийг цахимын хяналтын хасагдал эзэлж байгаа бөгөөд үүний ихэнх хувь нь зайлшгүй шаардлагын улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй байдагтай холбоотой байна.

Иймд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцооны үр дүн, ач холбогдол, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлснөөр үүсэх давуу талыг иргэдэд сурталчлан таниулах, даатгалын шимтгэл төлөлтийн нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Мөн хасагдсан нэхэмжлэхийн 23.4 хувийг эмчийн хасагдал эзэлж байгаа бөгөөд хасагдаж байгаа нэхэмжлэхийн шалтгааныг тодорхойлж нэгдсэн ойлголтод хүрэх, тухайн чиглэлээр эмч нарын чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах, заавар, зөвлөмжийг тухай бүр өгч ажиллах нь зүйтэй юм.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс 2021 онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамж, аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга, аймгийн ЭМД-ын хэлтсийн даргын хамтран баталсан удирдамжийн дагуу даатгалын гэрээтэй ажиллаж байгаа лавлагаа шатлалын 2 эмнэлэг, 2 рашаан сувилал, 7 өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, 16 эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Тус хяналт шалгалтын ажлын дүнд 5 албан шаардлагыг хүргүүлж, 16,5 сая төгрөгийн дүнтэй 3 актыг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.

Мөн аймгийн ЭМД-ын хэлтсээс 2022 онд ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/27 дугаар тушаалаар Коронавируст халдвар /Ковид-19/-ын үед хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлсэн Хэрлэн сумын 3 өрхийн эрүүл мэндийн төвд 2021 онд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтэд хяналт, үнэлгээг хийсэн байна.

Мөн ЭМДЕГ-аас хяналт шалгалтыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны эмнэлэг, Бор-Өндөр сумын нэгдсэн эмнэлэг, 21 сум, тосгоны эрүүл мэндийн төвийг хамруулан хийжээ. Шалгалтаар 24 даатгуулагчийн өвчтөний хүндийн зэргийг бууруулсан үндэслэлээр 28.3 сая төгрөг, мөн өрхийн эрүүл мэндийн

төвөөс короновируст халдвар /Ковид-19/-ын үед гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ авсан даатгуулагч нь эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авсан хугацаатай давхардсан үндэслэлээр 6.88 сая төгрөгийн акт тогтоож нийт 35.2 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд эргүүлэн төвлөрүүлсэн байна.

Мөн өвчний түүх, эмчийн үзлэгийн хуудас, эмчлүүлэгчийн хэрэглэсэн эмийн хуудас, амин үзүүлэлтийн хуудас, сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас, сувилгааны тэмдэглэлийг батлагдсан журмын дагуу бүртгэх, хөтлөх талаар заавар, зөвлөгөөг өгчээ.

Аймгийн ЭМД-ын хэлтсийн төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг ЭМДЕГ-аас шийдвэрлэдгээс Шилэн дансны тухай хуульд заасан дагуу Шилэн дансны цахим системд бие даасан цэс үүсээгүйгээс аймгийн ЭМД-ын хэлтсээс мэдээлэл оруулах боломжгүй байна.

Харин аймгийн ЭМД-ын хэлтсээс Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, 5.8-д заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олгогдож байгаа санхүүжилтийн мэдээллийг сар бүрийн өссөн дүнгээр мэдээллийн самбарт байршуулахаас гадна аймгийн ЗДТГ, ЭМГ, аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Холбогдох байгууллагын санал:



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭС**

Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23110
Утас/Факс: (976) 7056 2001,
Цахим шуудан: khentii@emd.gov.mn,
Цахим хуудас: www.emd.gov.mn

2023.05.19 № 32/60.
танай _____-ны № _____-т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Санал байхгүй.

ДАРГА



С.ХЭНЧМЭДЭХГҮЙ

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Эрүүл мэндийн салбарт ЭМД-ын тухай хууль хэрэгжиж, цахим системд бүрэн холбогдсоноор иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сайжирч, ЭМБ-ууд бие даан үйл ажиллагаа явуулахад дэвшил гарсан байна.
- ЭМД-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөө болон малчин, оюутан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь батлагдсан хүний нөөцийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг журмын дагуу хянаж, санхүүжилтийг олгож байгаа ч нэхэмжлэлийн хяналтын хасагдлын мэдээлэл, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад бүрэн хүргүүлэхгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулдаггүй байна.
- ЭМДЕГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч лавлагаа болон анхан шатны 30 байгууллагатай байгуулсан 2022 оны даатгалын гэрээг дүгнээгүй байна.
- Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх өрх, сум, тосгоны ЭМТ болон эмийн хөнгөлөлт үзүүлэх хувийн хэвшлийн эмийн сангуудад даатгалын гэрээний дагуу даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний урьдчилгаа олгодоггүй байна.
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн ажиллах хүчний дутагдал, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг аймгийн ЭМГ-т зохион байгуулж хуваарилдгаас шалтгаалан эм тарианы тасалдал үүсэж байгаа зэрэг нь тусламж, үйлчилгээний чанар, төрөл, гүйцэтгэлийн санхүүжилтэд сөргөөр нөлөөлж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав-д:

- Сумдын ЭМТ нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа тул эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулах боломжийг судалж шийдвэрлэх;

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Нямхатан-д:

- ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийг даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Доржханд-д:

- Анхан шатны ЭМБ-дын мэргэжлийн боловсон хүчнийг төлөвлөх, сургах, урамшуулах замаар хэрэгцээт хүний нөөцөөр хангах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга С.Хэнчмэдэхгүй-д:

- Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх өрх, сум, тосгоны ЭМТ болон эмийн хөнгөлөлт үзүүлэх хувийн хэвшлийн эмийн сангуудад даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний урьдчилгаа төлбөрийг гэрээний дагуу тогтсон хугацаанд олгож байх;
- Эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хасагдлын мэдээллийг холбогдох журмын дагуу бүрэн хүргэж ажиллах;
- Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын гэрээний биелэлтийг “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийг үнэлэх, урамшуулал олгох журам”-ын 2.1 дэх заалтад заасан хугацаанд дүгнэж байх;

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 дугаар сарын 19


Дугаар 4/13

Чингис хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар “Журам батлах тухай” тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст тус тус хүргүүлж, audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж дүнг тооцон ажиллахыг аудитын баг, ахлах аудитор Д.Эрдэнэбилэгт даалгасугай.
4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг холбогдох журмын дагуу архивын нэгж болгохыг аудитын баг, ахлах аудитор Д.Эрдэнэбилэгт даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Д.Оюунтуяад даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР

